



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/721

Ховд

Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1, Төрийн албаны зөвлөлийн “Зөвшөөрөл олгох тухай” 2019 оны 44, 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр хавсралтаар, Байгаль орчин, аялал жуучлалын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар хавсралтаар, Биеийн тамир, спортын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар хавсралтаар, Боловсрол, соёл, урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр хавсралтаар, Орон нутгийн өмчийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар хавсралтаар, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар хавсралтаар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар хавсралтаар, Эрүүл мэндийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж албан тушаалын тодорхойлолтыг мөрдүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

2019.11.05
Zax A/721 6h